


# ТЭГЭР



Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн  $47^{\circ}55^I$ , зүүн уртрагийн  $106^{\circ}55^I$ -ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд Лондон хотоос 7 цаг 08 минутын зөрүүтэй оршиж байна.



Нийслэлийн жилийн дундаж температур нь  $-3^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 1-р сарын температур нь  $-26^{\circ}\text{C}$  байх бөгөөд  $-30^{\circ}\text{C}$ -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна.



Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ний орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур  $0^{\circ}\text{C}$ -аас доош буухгүй.



Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь  $17^{\circ}\text{C}$ , хамгийн халуун болсон нь  $38^{\circ}\text{C}$  хүрсэн. Зундаа  $30^{\circ}\text{C}$ -аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг.



Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м\с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй.



Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1 дүгээр сард 70 орчим хувь, 7 дугаар сард 60 орчим хувь байдаг.

Улаанбаатар хотын газар нутгийн хэмжээ 4.7 мянган км<sup>2</sup> буюу Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 0.3 хувьтай тэнцдэг.



Нийслэл хот засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хувьд 9 дүүрэг, 152 хороотой. Орон сууцны хороолол бүхий 28 хороо, гэр хорооллын 65 хороо, 59 нь орон сууц, гэр хороолол зэрэгцсэн холимог хороо юм.



Нийслэл хот 1.2 сая гаруй хүн ам, нийт 307 орчим мянган өрх байнга оршин суудаг. Нийт өрхийн 2.6 хувь буюу 7833 нь 8 ба түүнээс дээш ам бүлтэй байна. Нийслэлийн 6959 өрх 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй.



Сүүлийн 8 жил нийслэл хотод жилд дунджаар 22.7 мянган хүүхэд шинээр төрдөг. 2011 онд хамгийн их буюу 30226 хүүхэд мэндэлсэн байна.



Нийслэлийн суурин хүн амын 17.7 хувь нь 0-9 насны хүүхэд байна. Харин 10-19 насны хүүхэд нийт суурин хүн амын 15.6 хувийг эзэлдэг.



Нийслэлийн суурин хүн амын 21.6 хувь нь 20-29 насны, 17.6 хувь нь 30-39 насны, 13.3 хувь нь 40-49 насны, 8 хувь нь 50-59 насны, харин 60 ба түүнээс насны хүн ам 6.2 хувийг эзэлж байна.



2006-2009 онуудад нийслэл хотод жилд дунджаар 16.3 мянган хос албан ёсоор гэрлэлтээ бүртгүүлж байв. Харин 2010 онд 3933, 2011 онд 5278 хос гэрлэлтээ албан ёсоор бүртгүүлжээ.



Нийслэл хотод 2006-2009 онд жилд дунджаар 1215 хос гэрлэлтээ албан ёсоор цуцлуулж байв. Харин 2010 онд 1631, 2011 онд 1785 хос албан ёсоор гэр бүлээ салгажээ.



Нийслэлийн 37.4 мянган хүн өөрийгөө хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлдог. Харин эдгээр хүмүүсийн 27 мянгыг нь эмчийн албан ёсны дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй гэжээ. Хөгжлийн бэрхшээлтэй нийт хүмүүсийн 47.3 хувь эмэгтэйчүүд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 30 орчим хувь нь төрөлхийн, 57 хувь нь өвчнөөр, харин 13 хувь нь гэнэтийн ослоос шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй болжээ.



Улаанбаатар хотод бүтэн өнчин 1662 хүүхэд байна. Эдгээр хүүхдийн 143 нь 0-6 насны, 293 нь 7-9 насны хүүхдүүд юм. Мөн хагас өнчин 10684 хүүхэд Улаанбаатар хотод суурин амьдарч байна.



Хотын гудамжаар тэнүүчилж байсан 1033 хүүхэд төрийн болон төрийн бус байгууллагын халамжийн төвүүдэд амьдарч байна.



Улаанбаатар хотод 3 мянга гаруй ганц бие өндөр настан амьдардаг. Нийслэлд 505 өндөр настан тэтгэвэр, тэтгэмжээ огт тогтоолгоогүй хэвээр байна.



Нийслэлийн суурин хүн амын бараг 53 хувь нь бусад хот, аймгаас шилжиж иржээ. Нийслэлийн нийт хүн амын 47.2 хувь нь Улаанбаатар хотод, 15.4 хувь нь хангайн бүс нутагт, 14.7 хувь нь баруун бүсэд, 14.1 хувь нь төвийн, 6.4 хувь нь зүүн бүс, харин 2.2 хувь нь гадаадад төрсөн байна.

Сүүлийн жилүүдэд жилд дунджаар 33 орчим мянган хүн Улаанбаатар хотод албан ёсоор шилжин ирж, харин 11 мянган хүн шилжин явжээ.

Жилд дунджаар 450 орчим мянган гадаадын жуулчид манай хотод айлчлан ирдэг.



Улаанбаатар хотын нийт өрхийн нэг хувь нь тусдаа тохилог орон сууцанд, 39.5 хувь нь нийтийн орон сууцанд, 32.7 хувь нь байшинд, 26.6 хувь нь монгол гэрт амьдарч байна. Харин 515 өрхийн 1367 хүн орон гэргүй байна.





Улаанбаатар хотын нийт өрхийн 98.4 хувь нь төвлөрсөн системээс, 0.2 хувь нь сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмжөөр, 0.3 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэгцээгээ хангадаг.



Нийт өрхийн 1.1 хувь нь цахилгааны ямар нэг эх үүсвэрт холбогдоогүй байна. Цахилгаангүй өрхийн 81 хувь нь гэрт амьдардаг бөгөөд эдгээр өрхийн 34 гаруй хувь нь Баянзүрх, 35 хувь нь Сонгинохайрхан дүүрэгт байна.



Улаанбаатар хотын нийт өрхийн 38 гаруй хувь нь ундны усаа төвлөрсөн системээр шууд, 21 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байрнаас, 4.7 хувь нь хамгаалагдсан худгаас, 0.1 нь хамгаалагдсан булаг, шандаас

авдаг. Харин нийт өрхийн 32.7 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас, 2.8 хувь нь зөөврийн ус, 0.6 хувь нь гол мөрөн, нуур, хамгаалагдаагүй худаг, булаг шандаас ундны усаа авч байна.



Улаанбаатар хотын нийт өрхийн 36.5 хувь нь усанд орох байнгын суурилуулсан онгоц, шүршүүрийн өрөөтэй.

Нийслэлийн нийт өрхийн 38.1 хувь нь сууцны дотор, харин 60.9 хувь нь сууцны гадна бие засах газартай бол 0.9 хувь нь тогтсон бие засах газаргүй. Нийт өрхийн 60 орчим хувь нь бие засах газраа дангаараа ашигладаг байна.



Нийт өрхийн 38 хувь нь төвлөрсөн системээр, 0.3 хувь нь бие даасан системээр бохир усаа зайлуулдаг бол 54 хувь нь цооногт, 8 орчим хувь нь задгай асгаж байна.



Нийт өрхийн 93 орчим хувь нь хатуу хог хаягдлаа үйлчилгээний байгууллагаар дамжуулан зайлуулдаг. Харин нийт өрхийн 3.8 хувь нь өөрсдөө зөвшөөрөгдсөн цэгт, 3.5 хувь нь дуртай газраа хаядаг.

Улаанбаатар хотын нийт өрхийн 38.8 хувь нь хүйтний улиралд төвлөрсөн системээр, 4.7 хувь нь нам даралтын зуухнаас халаалт авдаг. Харин нийт өрхийн 0.6 хувь нь цахилгаан халаагуур, 55.8 хувь нь ердийн галлагаагаар гэрээ халаадаг байна.





Нийт өрхийн 52.4 хувь нь хоол ундаа ихэвчлэн цахилгаанаар болгодог. Харин 45.8 хувь нь мод, нүүрс, шахмал түлш, аргал, хөрзөнгөөр, 1.8 хувь нь савласан хийгээр хоол ундаа болгож байна.



2012 оны эхний 9 сард кабелийн телевизийн 16 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, нийслэлийн 175.0 мянган хэрэглэгчдэд үйлчилжээ. Кабелийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн 94.2 хувийг айл өрх эзэлж байна.



Нийслэл хотын 70 гаруй мянган өрх гэртээ суурин телефон утастай.

Нийслэлийн 6 ба түүнээс дээш настай нийт хүн амын 87 хувь нь гар утас хэрэглэж байна.



Улаанбаатар хотод 210 орчим мянган тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн байна. Нийслэлийн хоёр өрх тутмын нэг нь автомашинтай.



Улаанбаатар хотын нэг оршин суугч сард дунджаар 7 орчим кг мах, 7 литр сүү, 400 гр цөцгийн тос, 6 ширхэг өндөг, 11 кг гурил, талх, нарийн боов, 1 кг сахар, чихэр, 2 кг будаа, 4 кг төмс, 3 кг хүнсний ногоо, 800 гр жимс, жимсгэнэ хэрэглэж байна.

Нийслэлийн нийт хүн амын 23.5 хувь нь ядуурлын шугамнаас дунджаар 5.9 хувиар доогуур хэрэглээтэй байна.



Монгол улсын эдийн засгийн идэвхтэй хүн амын 34.0 хувь, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн 34.8 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна.



Улаанбаатар хотын хөдөлмөрийн насны 100 хүн бүр 49 хүнийг тэжээж байна. Эдгээр хүмүүсийн 40 нь хүүхэд, 9 нь хөдөлмөрийн нас хэтэрсэн хөгшчүүд юм.



2012 онд нийслэлд 680 га талбайгаас 5 мянга гаруй тонн төмс, 438 га талбайгаас 3 мянга гаруй тонн хүнсний ногоо хураан авав. Хурааж авсан нийт ургацын 81.7 хувийг өрхүүд хураан авсан байна.



2012 оны эхний 9 сард Улаанбаатар хотод 277.6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 370 барилга объектыг ашиглалтад оруулав. Тухайлбал, 6220 айлын хүчин чадалтай 83 барилгыг улсын комисст хүлээн авчээ.



Улаанбаатар хотод 2750 шахам нийтийн хоолны газрууд, 7000 орчим ор бүхий 220 гаруй зочид буудал жилийн турш үйл ажиллагаа явуулдаг.



Улаанбаатар хотод өдөр бүр 3512 хүнсний дэлгүүр, 90 бөөний худалдааны төв, 22 зах, 619 түргэн үйлчилгээний цэгүүд ажиллаж байна. Нийслэлийн нэг өдөрт 2.3 тэрбум төгрөгийн жижиглэн худалдаа, 9 тэрбум төгрөгийн бөөний худалдаа хийдэг.



Нийслэл хотод жилийн турш 225 спортын заал, танхим ажилладаг. Жилд дунджаар 6 мянган тамирчдыг хамруулсан нийслэл хотын аварга шалгаруулах 64, баяр ёслол, тэмдэглэлт ойн зэрэг 142 тэмцээн зохион байгуулж байна.



2012 оны эхний 11 сард 11584 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 16.8 хувь буюу 1664 хэргээр өсчээ. Гэмт хэргийн улмаас 4605 хүн гэмтэж осолдсоноос 7.1 хувь нь буюу 329 хүн нас барав.



Бүртгэгдсэн гэмт хэргийн 28.5 хувийг хүний эрх, эрх чөлөөний эсрэг, 25.6 хувийг хулгайн, 9.6 хувийг танхайн, 8.9 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг, 7.3 хувийг залилангийн хэрэг эзэлж байна.

2012 оны эхний 11 сард 56766 хүн эрүүлжигдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.8 хувь буюу 2588 хүнээр өссөн байна.



Нийтийн зорчигч тээврийн их, дунд багтаамжийн автобусыг дунджаар 7.5 минут, троллейбусыг 5.3 минут, микроавтобусыг 6.9 минут хүлээж байна.

НИЙСЛЭЛИЙН СТАТИСТИКИЙН ГАЗАР